



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/471

Булган сум

Төрийн байгууллагуудын ажлын цагийн  
хуваарьт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 84 дүгээр зүйлийн 84.2, 94 дүгээр зүйлийн 94.1, 94.2, 94.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуусталхи хугацаанд аймгийн нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудын ажлын цагийг өглөө 08.00 цагаас 17.00 цаг хүртэл, амрах хооллох завсарлагын цагийг 12.00-13.00 цагийн хооронд байхаар зохицуулсугай.

2.Захирамжийг иргэд, олон нийтэд мэдээлж, хэрэгжилтийг хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай), сумын Засаг дарга, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010429